



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/206

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох,
хүчингүй болгох тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3, 19.22, Эрүүл мэндийн яамны "Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс"-ын 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр олгох байгууллагын нэрсийг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох байгууллагын нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эм хангамжийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080670

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 05 сарын 17-ны өдрийн
А. дугаар тушаалын 1 дүгээр
1206 хавсралт

**ЭМ ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР БОЛОН НЭМЭЛТЭЭР ОЛГОХ
БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
Шинээр олгох			
1	Чирон ХХК	эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
2	Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв	протез үйлдвэрлэх, худалдах	3 жил
3	Цэргийн төв эмнэлэг	Нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээ	3 жил
Нэмэлтээр олгох			
1	Мөнгөн марал ХХК	эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез импортлох, ханган нийлүүлэх	3 жил

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 05 сарын 17-ны өдрийн
А/... дугаар тушаалын 2 дугаар
1206 хавсралт



**ЭМ ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХУЧИНГҮЙ БОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
Тусгай зөвшөөрөлд заасан хаяг байршилдаа байгаа боловч үйл ажиллагаа явуулаагүй байгууллагууд		
1	Оном ХХК	Эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ
2	Мануул трейд ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх
3	Универсаль мед ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур импортлох, ханган нийлүүлэх
4	Сити энержи ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл /оношлуур/ импортлох, ханган нийлүүлэх
5	Монголлин руй ХХК	Эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх
Ажлын байрны бүтэц, зохион байгуулалт, хүн хүчний хангамж нь стандартын шаардлага хангаагүй байгууллагууд		
1	Монэнзим мед ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх, импортлох
2	Интимэйт ХХК	Эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх
Тусгай зөвшөөрөлд заасан хаяг байршилдаа байгаагүй байгууллагууд		
1	Цагаан овоо фарм ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх
2	Ай он центр ХХК	Нүдний эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх